



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарыг 28 өдөр

Дугаар 9/232

Мандатгүй

Г Газар эзэмшүүлэх тухай 7

Монгол Улсын Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын төвийн 7 дугаар багийн нутаг дэвсгэр /Бөмбөлөг дэлгүүрийн баруун талд/-т байршилтай 414 м.кв /0.0414га/ газрыг аймгийн Засаг даргын тамгын газар /3429792/-т төрийн үйлчилгээний зориулалтаар 30 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Аймгийн Засаг даргын тамгын газартай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Э.Чагнаадорж/, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч /Р.Мөнхтогтох/, аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/ нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200556